



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Боловсрол соёлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/137/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: **З.Мөнгөнцэцэг**

Утас: **9937-2208**

Цахим хаяг: Munguntsetseg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАНД
ТОРИЙН АУДИТЫН ГАЗАР**

4200 Дархан-Уул аймаг
Сүхбаатар, 14-д баг
Утас: 7277-3015, 4640, 3076; 7031-3088
E-mail: darhan@ad.audit.gov.mn

2022.12.18 № 91
Утас: _____

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

БОЛОВСРОЛ СОЁЛ УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ГАЛБАДРАХ ТАНАА



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Боловсрол соёл урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/эмнийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Боловсрол соёл урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв тохируулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгалдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний дүгнүүлсэн хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тохируулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлох, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ өнгөд эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дэнгирийн эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЖЛАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНХБАЯР



009020304

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	21.6	24.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	260.3	202.5
	Нийт хөрөнгийн дүн	282.0	226.7
	Нийт өр төлбөрийн дүн	2.5	0.02
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	279.5	226.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	282.0	226.7
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,286.7	2,441.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,356.6	2,491.9
	Үйл ажиллагааны үр дүн	(69.9)	(50.1)
	Үйл ажиллагааны бус үр дүн	(6.0)	(3.5)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(75.9)	(53.6)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	460.3	280.3
	Тайлант оны үр дүн	(75.8)	(53.6)
	Эцсийн үлдэгдэл	279.5	226.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,157.1	2,308.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,157.1	2,269.0
	Үйл ажиллагааны ЦМГ		39.4
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		(39.4)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,103.8	2,060.7
	Урсгал зардал	2,103.8	2,060.7
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,103.8	2,060.7
	Улсын төсвөөс санхүүжих	2,103.8	2,060.7

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Боловсрол соёл урлагийн газар нь хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, шийдвэр, боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, соёлын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлж, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн Боловсрол соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг 5,12 дугаар саруудаас бусад саруудад, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг 1-3 дугаар улиралд тус тус мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 210,075.6 мянган төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 227,020.9 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илрүүлснээс 13,669.6 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 1,520.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 210,075.6 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулах албан шаардлага, 1,755.2 мянган төгрөгийн алдаа зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

- Бараа материалын дэлгэрэнгүй тайланг тооллогын бүртгэлтэй тулгахад зөрүү гараагүй боловч 1,620.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 11,081.8 мянган төгрөгийн аж ахуйн материалыг тушаал, шийдвэргүйгээр акталж, зардлаар тайлагнасныг буцаах бичилтээр залрууллаа.

- Тус байгууллагын өр төлбөрийн үлдэгдэлд тулгалт хийхэд Монголын цахилгаан холбоо ХК-ний 22.4 мянга, Энхханжаргалан ХХК-ний 100.0 мянган төгрөг тооцоо нийлсэн актаар өр төлбөргүй, мөн 680.0 мянган төгрөгийн өр нь олон жилийн насжилттай, эзэн холбогдогчгүй өглөг тул нийт 802.4 мянган төгрөгийг өглөгийн данснаас залруулсан.

- Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг 134.5 мянган төгрөгөөр нийгмийн даатгалын тайланд илүү тооцож, уг тэтгэмжтэй холбоотойгоор Б.Өнөрбаянд 30.8 мянган төгрөгийн цалин илүү олгосныг авлагын дансанд залруулав.

Төлбөрийн акт

- Газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Галбадрахад удирдахуй ухааны доктор (Ph.d) зэргийн нэмэгдэлд 569.4 мянган төгрөг илүү олгосон, үйлчлэгч Э.Жаргаланд тушаал шийдвэргүйгээр 423.6 мянган төгрөгийн бохирын нэмэгдэл олгосон, ахлах мэргэжилтэн Б.Алтанчимэгт 260.5 мянга, Д.Соёлмаад 267.1 мянган төгрөгийн түр орлон гүйцэтгэсний нэмэгдлийг илүү олгосонд тус тус төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

- Тус газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Галбадрахыг аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01-Б/61 дугаар захирамжаар түр томилсон байна. Харин Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 411 дүгээр тогтоолд сонгон шалгаруулалтгүйгээр, Төрийн албаны тухай хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага хангагдаагүй томилсон албан хаагчийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон албан үүргээс чөлөөлөхөөр тусгасан тул томилох эрх бүхий албан тушаалтанд дээрх тогтоолыг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

- Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг 5,12 дугаар саруудаас бусад саруудад, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг 1-3 дугаар улиралд тус тус мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 210,075.6 мянган төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцроосонд мөн албан шаардлага өгөв.

Зөвлөмж

Байгууллагын 2021 оны цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/200 дугаар захирамжаар байгууллагын дарга С.Галбадрахад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,035.2 мянган төгрөгийн мөнгөн шагнал олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 онд баталсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” 5 дугаар тушаалын “Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлын ангилалд ажиллагсдын цалин, хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд хамаарна” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаад зөвлөмж хүргүүлсэн.

Тус газрын даргын 2021 оны Б/18, Б/33 дугаар тушаалаар мэргэжилтэн Д.Оюунбилэг, С.Мандалхүү, П.Болорцэцэг, О.Ууганчимэг, Б.Өнөрхүү, Э.Жаргалан нарт Төрийн дээд, салбарын, аймгийн Засаг даргын шагналын дагалдах мөнгөн шагналд нийт 720.0 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгосонд мөн зөвлөмж хүргүүлээ.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудит ад	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ		1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	9	227.0	3	13.7	3	1.5	2	210.0	1	1.7
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
НИЙТ		9	227.0	3	13.7	3	1.5	2	210.0	1	1.7